

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

ХҮНИЙ ХӨГЖИЛ, БҮСИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ-БИД ХАМТДАА

1. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО:

Олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангана.

1.1. Эдийн засгийн бодлого зохицуулалтын чиглэлээр: Эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, бүтцийг төрөлжүүлж, эдийн засгийн өсөлтийг ханган иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.

1.1.1. Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний одоогийн байгаа түвшинг бууруулахгүйгээр цаашид нэмэгдүүлнэ.

1.1.2. Хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тогтоон, жижиг дунд үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлж, хөрөнгө оруулалт, зээл тусламжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангана.

1.1.2.1. Үйл ажиллагаа нь тогтмолжсон, шинэ техник, технологи нэвтрүүлж, ажлын байр шинээр бий болгох боломжтой, үйлдвэр эрхлэгчдийг “Сум хөгжлийн сан” болон “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.1.2.2. Бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлт” бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1.3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэхэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар Ногоон эдийн засгийг дэмжинэ.

1.1.3.1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн тодорхой хувийг байгалийн нөөцийн хэмнэлттэй, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд зарцуулна.

1.1.4. Орчин үеийн техник, технологи бүхий томоохон үйлдвэрүүдийг байгуулах, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх үйлдвэржилтийн аян өрнүүлж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно.

1.1.4.1. Цементний үйлдвэр байгуулахад орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлнэ.

1.1.4.2. Арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих ажлыг эхлүүлнэ.

1.1.5. Татварын бааз, суурийг өргөтгөж, сахилгыг сайжруулан, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.1.6. Санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулж, төсвийн үргүй зардал, өр, авлагыг бууруулна.

1.1.6.1. Төсвийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, хэрэгжилт, тайлагналтыг цахим хэлбэрээр нэгтгэх тогтолцоог хэрэгжүүлнэ.

1.1.6.2. Төрийн сангийн хэлтэс, албадыг өндөр хурдтай сүлжээний тоног төхөөрөмжөөр хангаж, санхүүгийн программын шинэчлэлтийг хийнэ.

1.1.7. НББ-ийн хөтлөлтийг сайжруулах замаар санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.1.7.1. Нягтлан бодогч нарт бүртгэлийн олон улсын стандартын сургалтыг зохион байгуулж, нягтлан бодогчдыг мэргэшүүлнэ.

1.1.7.2. Нягтлан бодох бүртгэлийн “Тунгалаг бүртгэл” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.1.8. Орон нутгийн өмчийн харилцааны оновчтой бодлогыг тодорхойлж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, орон нутгийн өмчит газруудын санхүүгийн үр ашгийг дээшлүүлнэ.

1.1.8.1. Өмчийн мэдээллийн сан бүрдүүлж, бүртгэлийг цахимд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.1.8.2. ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, удирдлагын менежментийг сайжруулж, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.1.9. Худалдан авах ажиллагааг ил тод болгож, аж ахуйн нэгж, байгууллагуудад өрсөлдөх тэгш боломжийг хангана.

1.1.9.1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, дүгнэж тайлагнана.

1.1.9.2. Хөрөнгө оруулалтын зарцуулалтад хяналт тавьж чанар, үр өгөөжийг сайжруулна.

1.1.10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг нэмэгдүүлнэ.

1.1.10.1. Эдийн засгийн үр ашигтай, төсөл хөтөлбөрийг сурталчлан дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах үйл ажиллагааг зохион байгуулна.

1.1.10.2. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэрийг ашиглан зохион байгуулж, харилцан ашигтай хамтын ажиллагааны механизм бүрдүүлнэ.

1.2. Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үр ашгийг нэмэгдүүлж, малчдын орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.

1.2.1. Малын ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэн бэлтгэн нийлүүлэлтийн үр ашигтай сүлжээг бий болгоно.

1.2.1.1. Аймагт сайжруулагчаар ашиглаж буй үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн малын үржил селекцийн ажлыг сайжруулах “Шилмэл мал” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.2.1.2. Сутай омгийн хонийг үүлдрээр, Мянгад суманд үржүүлж буй Мянгад адууг омгоор баталгаажуулж, Торгууд хонийг сайжруулагчаар ашиглана.

1.2.1.3. Баталгаажсан үүлдэр, омгийн малын стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч бойжуулах цөм сүргийн үржлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжинэ.

1.2.1.4. Малын үржлийн ажил үйлчилгээнд шаардагдах төсөв санхүүжилтийг шийдвэрлэнэ.

1.2.1.5. Сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг, үйлчилгээний нэгжүүдийг өргөжүүлж, ажиллах нөхцлөөр хангаж, мэргэшүүлнэ.

1.2.1.6. Аймгийн шилмэл малын үзэсгэлэн худалдааг аймаг, сумын хэмжээнд 2 жилд 1 удаа зохион байгуулна.

1.2.1.7. Нийт мал сүргийг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах, ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх, шилмэл малын мэдээллийн санг баяжуулах ажлыг эрчимжүүлнэ.

1.2.1.8. Тэмээн сүргийн тоо толгойг өсгөх болзол журам гаргаж, ингэний сүү, хоормогийг үндэсний тохирлын тэмдэгтэй болгож, аймгийн брэнд бүтээгдэхүүн болгоно.

1.2.1.9. Сарлагийн тоо толгойг өсгөн үржүүлэх бодлого гаргаж, зэргэлдээ аймаг, сумдаас өсвөр хээлтүүлэгч авч сайжруулагчаар ашиглахад дэмжлэг үзүүлнэ.

1.2.2. Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлж, бэлчээрийн усан хангамж, даацад тохирсон мал аж ахуй эрхлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.

1.2.2.1. Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгийг аймаг, сумын түвшинд тогтоож мөрдүүлнэ.

1.2.2.2. Нутгийн малын ашиг шимийн түвшинг тогтоох үзлэг, ангилалтыг жил бүр хийж, үржлийн ажлын бодлого чиглэлийг тодорхойлно.

1.2.2.3. Сум бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан, мөрдүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулна.

1.2.2.4. Жил бүр 10 хүртэл инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, худаг, уст цэгийн бүртгэл мэдээллийн сан бий болгож, эзэмшил, ашиглалтыг сайжруулна.

1.2.2.5. Уст цэгийн хайгуул, судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлж, шаардлагатай сумдад хөв, цөөрөм байгуулах ажлыг дэмжинэ.

1.2.2.6. Бэлчээрийн хортон шавжтай тэмцэх арга хэмжээг жил бүр зохион байгуулж, шинээр хортон шавж, мэрэгч тархаж байгаа газар нутгийн судалгаа гаргаж, тархацыг бууруулна.

1.2.2.7. Хадлан, тэжээл бэлтгэх болзол журам гаргаж, хадлангийн механикжсан салаа байгуулах, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.2.3. Залуу малчдыг малжуулах замаар малчдын залуу халааг бий болгоно.

1.2.3.1. Мал аж ахуй эрхэлж буй малчин залуучуудыг дэмжих “Залуу малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.3.2. Мал аж ахуйн салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа малчдыг урамшуулах системийг боловсронгуй болгоно.

1.2.4. Хоршоо, фермерүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.

1.2.4.1. Булган, Манхан, Зэрэг, Дарви, Жаргалант, Мянгад сумдад мах, сүүний чиглэлийн фермийн аж ахуйг дэмжиж, төв суурин газрын хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.

1.2.4.2. Хот суурин газрын ойролцоо гахай, тахиа, зөгийн туслах аж ахуйг байгуулах иргэн, аж ахуй нэгжүүдийг дэмжиж, хүн амын хүнсний хэрэгцээг хангана.

1.2.4.3. Мал аж ахуй, туслах аж ахуй, газар тариаланг ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор болгон хослуулан хөгжүүлэх аймгийн нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлж, “Ховд агро парк” төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.2.4.4. Малчдын “Нүүдэлчин” төвийг төр, хувийн хэвшлийн оролцоотой байгуулна.

1.2.5. Мал эмнэлгийн тогтолцоог сайжруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлнэ.

1.2.5.1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх био бэлдмэл, вакцин, ийлдэс, оношлуурыг жил бүрийн төсөвт тусгуулж, мал сүргийг эрүүлжүүлнэ.

1.2.5.2. Шүлхий болон гоц халдварт өвчнөөр намжмал, статусыг хангахын тулд жил бүр тандах шинжилгээ хийж, гарсан урвалын дагуу хариу арга хэмжээ авч, шуурхай бэлэн байдлыг хангана.

1.2.5.3. ХХАА-н газрын конторын барилгыг, лабораторийн хамт шинээр барина.

1.2.5.4. Мах, сүү, хүнсний ногооны шинжилгээний лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлж хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах нөхцөл бүрдүүлнэ.

1.2.5.5. Сумдад мал угаах суурин ванныг шинээр барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

1.2.5.6. Хавар намрын угаалга, туулга, боловсруулалт, хашаа хороо, өтөг бууцын ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмолжуулна.

1.2.6. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүнсний ногоо, тэжээлийн ургамлын тариалалт, үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.

1.2.6.1. Тариалангийн талбайн хэмжээг 3000 га-д хүргэж, ажлын байр нэмэгдүүлсэн үйлдвэрлэгчдийг дэмжинэ.

1.2.6.2. Алтай, Буянт, Булган, Үенч, Дарви, Манхан, Ховд, Эрдэнэбүрэн сумдын атаршсан талбайд үр тариа, улаан буудай, тэжээлийн ургамал, тосны ургамал тариалах тариалалтын хэмжээг нэмэгдүүлж, бүсчилсэн тэжээлийн үйлдвэр, цехүүдийг байгуулна.

1.2.6.3. Төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг байгуулна.

1.2.6.4. Эрдэнэбүрэн сумын услалтын системийг сэргээж, Алтай, Булган, Буянт, Дарви, Үенч, Ховд сумдад усалгаатай газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.2.6.5. 500 тонн хүртэл багтаамж бүхий механикжсан зоорь барина.

1.2.6.6. Жимс, жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлж, тариалах иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.

1.2.6.7. Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, лабораторийн шинжилгээгээр баталгаажсан үрээр тариалалт хийж, чанартай, аюулгүй экологийн цэвэр хүнсийг зах зээлд нийлүүлнэ.

1.2.6.8. Тариаланчдыг бага, дунд оврын хүчин чадалтай трактор, чиргүүл, дүүжин машин, үрлэгчээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

1.2.6.9. Тариаланчдыг био бордооны зүй зохистой хэрэглээний сургалтанд хамруулж, хяналт тавина.

1.2.6.10. “Эко хүнс” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3. Худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр:

Бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх замаар шинэ техник, технологи бүхий худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.3.1. Баруун бүс нутгийн зах зээлийн хэрэгцээг хангахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.

1.3.1.1. Барилгын хөнгөн блок, өнгөлгөөний тоосгоны үйлдвэрүүдийн үйл ажиллагааг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.3.1.2. Барилгын туслах материал болох хадаас, замаск, шохойн үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.

1.3.2. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулна.

1.3.2.1. Ноос, ноолуур угаах үйлдвэр байгуулах төслийг дэмжинэ.

1.3.2.2. Малыг үйлдвэрийн аргаар нядалж, махыг ангилж, савлах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

1.3.2.3. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

1.3.3. “Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сан”, “Сум хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг байгалийн нөөцийн хэмнэлттэй дэвшилтэт технологид суурилуулсан, ажлын байр шинээр бий болгох үйлдвэрүүдэд хөрөнгө оруулахад зарцуулна.

1.3.3.1. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж дотоодын хэрэгцээг хангана.

1.3.3.2. Сумдыг бүсчлэн ноос угаах, эсгий үйлдвэрлэх цех байгуулахад хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.3.3.3. Гялгар уут, хуванцар сав, хаягдал шил дахин ашиглах, боловсруулах жижиг дунд үйлдвэрийг дэмжинэ.

1.3.3.4. Ажлын болон хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэгчээр ажиллах оёдлын үйлдвэрүүдийг дэмжинэ.

1.3.3.5. Эрүүл мэндийн чиглэлээр үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

1.3.4. “Ховд брэнд бүтээгдэхүүн” бий болгоно.

1.3.4.1. Аймгийн “Ховд брэнд бүтээгдэхүүн”-ийг шалгаруулах журам батлуулж хэрэгжүүлнэ.

1.3.4.2. Хоршооны гишүүн малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг нэмэгдүүлж, экологийн цэвэр, брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ.

1.3.5. Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлэх, экспортыг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэгчдийг дэмжинэ.

1.3.5.1. “Хаврын өнгө”, “Ховдын хөгжил” үзэсгэлэн худалдааг аймгийн төвд жил бүр, Булган суманд хилийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.

1.3.5.2. Экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, нийслэл Улаанбаатар болон БНХАУ, ОХУ-д зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэгчдийг оролцуулна.

1.3.6. Иргэдэд хүргэж буй худалдаа, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, стандартад нийцүүлнэ.

1.3.6.1. “Эвийн хүч” худалдааны төв битүү захын үйл ажиллагааг эхлүүлж жигдрүүлнэ.

1.3.6.2. Үндэсний тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний нэр төрөл тоог нэмэгдүүлнэ.

1.3.6.3. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулж, хэрэглэгчдийг баталгаат хүнсээр хангана.

1.3.7. Ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээг иргэдэд ойртуулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.7.1. Шинээр болон сэргээн засварлаж байгуулсан ахуйн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг жигдрүүлж, иргэдэд үйлчилгээг ойртуулна.

1.3.7.2. Ховд брэнд бүтээгдэхүүн бий болгох, аялал жуучлал хөгжүүлэх зорилгоор жил бүр ахуйн үйлчилгээний өдөрлөгийг зохион байгуулна.

1.4. Дэд бүтэц, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлсэн, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийг хөгжүүлнэ.

1.4.1. Баруун бүсийн босоо, хэвтээ тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төслийн хүрээнд замын барилгын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулж, ашиглалт хамгаалалтыг сайжруулна.

1.4.1.1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Босоо тэнхлэгийн Ховд-Хашаатын даваа-Толбо сум, Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн хэсэгчилсэн 189.7 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна.

1.4.1.2. Концессын гэрээгээр хийгдэж буй Хэвтээ тэнхлэгийн Алтай хот-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна.

1.4.1.3. Булган-Үенч чиглэлийн авто замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтад оруулж, Мөст, Эрдэнэбүрэн сумын төвийг Босоо тэнхлэгийн авто замтай холбоно.

1.4.1.4. Булганы Байтаг боомтын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэн хатуу хучилттай авто замаар холбоно.

1.4.1.5. Аймгийн төв рүү орох, төвөөс гарах гурван чиглэлийн зам, Эрдэнэбүрэн сумын Хонгио, Манхан сумын гурван замын бэлчир, Булган суманд авто тээврийн шалган нэвтрүүлэх бүрэн тоногдсон пост ажиллуулж, тээврийн хэрэгсэлд даацын хяналтыг тавьж, авто замын ашиглалтыг сайжруулна.

1.4.2. Ховд хотын болон орон нутгийн зам, талбай, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, тохижилт, үйлчилгээний чанарыг сайжруулна.

1.4.2.1. Ховд хот дотор 10 км хатуу хучилттай авто зам барина.

1.4.2.2. Хот доторх хатуу хучилттай авто замын дагуу явган хүний зам болон дугуйн замын уртыг нэмэгдүүлнэ.

1.4.2.3. Хот доторх болон орон нутгийн авто зам, гүүрэн байгууламжид урсгал болон их засвар тогтмол хийдэг болно.

1.4.2.4. Ховд хотын гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлгийг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

1.4.2.5. Чандмань, Дуут, Мөнххайрхан, Ховд сумдын чиглэлд сайжруулсан хайрган зам тавина.

1.4.2.6. Цэцэг сумын төвийг Хөшөөтийн замтай, Мянгад, Дөргөн сумдын төвийг хатуу хучилттай авто замаар “Сар Хайрхан”-ны чиглэлийн авто замтай холбоно.

1.4.2.7. Чоно харайхын төмөр бетонон гүүр, Хомын хоолойн модон гүүрийг барьж ашиглалтад оруулна.

1.4.2.8. Сумын төвийн гэрэлтүүлэг, авто зам, тохижилтын ажил (Мянгад, Манхан, Ховд, Мөст, Чандмань, Эрдэнэбүрэн сум)-ын төслийг гүйцэтгүүлж ашиглалтад авна.

1.4.3. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

1.4.3.1. Хот доторх автобусны зогсоолуудыг тохижуулж, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, давтамжийг нэмэгдүүлнэ.

1.4.3.2. Жаргалант, Булган сумдад авто вокзалын үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.4.3.3. Олон улсын чанартай авто замын дагууд авто тээврийн үйлчилгээний төв байгуулах аж ахуйн нэгж, хувийн хэвшлийг дэмжинэ.

1.4.3.4. Аймгийн төвөөс сумдын чиглэлийн зорчигч, ачаа тээвэр, шуудангийн үйлчилгээний менежментийг сайжруулна.

1.4.4. Улсын хэмжээнд үр ашигтай, өрсөлдөхүйц, найдвартай агаарын болон авто тээврийн системийг хөгжүүлж, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоонд тулгуурлан транзит тээвэр, ложистикийн үйлчилгээг дэмжинэ.

1.4.4.1. Жаргалант, Булган суманд тээвэр ложистикийн төв байгуулна.

1.4.4.2. Аймгийн Нисэх буудлыг олон улсын ангилалд нийцүүлэн өргөтгөнө.

1.4.5. Сумдын дэд бүтцийг хөгжүүлж, орон нутагтаа ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.

1.4.5.1. Алтай, Дарви, Цэцэг, Мянгад, Чандмань сумдын төвийг дулааны нэгдсэн шугам сүлжээтэй болгоно.

1.4.5.2. Зарим сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.4.5.3. Дөргөн сумын төвийн ундны усны хангамжийг сайжруулж, Үенч, Алтай сумдад ус цэвэршүүлэх төхөөрөмж ажиллуулна.

1.4.5.4. Манхан сумаас Хөшөөтийн уурхай хүртэл 110кВ-ын ЦДАШ, Хөшөөтийн уурхайгаас Үенч сум хүртэл 35 кВ-ын ЦДАШ барина.

1.4.5.5. Сумдын ЦДАШ-ыг үе шаттай шинэчилж цахилгаан хангамжийг сайжруулна.

1.4.5.6. Байтаг, Ярантын боомтын ерөнхий төлөвлөгөөг хийлгэж, хөгжлийн цэгцтэй бодлогыг боловсруулж үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.

1.4.6. Ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан барилгын дулаан алдагдлыг бууруулж, чанарыг сайжруулж, ард иргэдийн эрүүл, аюулгүй, тохилог орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

1.4.6.1. Орон сууц нийтийн үйлчилгээний контор байгуулж, нийтийн орон сууцны засвар үйлчилгээ, ашиглалтыг сайжруулна.

1.4.6.2. Нийтийн орон сууцны орц, дээвэр, гадна орчны тохижилт, хэрэглээний халуун усны шугамыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

1.4.6.3. Бетон дүүргэгч, керамик материалын лабораторийг өргөжүүлж, орон нутгийн барилгын материалын чанарт хяналт тавина.

1.4.6.4. Цементийн лабораторийг шинээр байгуулж бүс нутагтаа чанарын шинжилгээг хийнэ.

1.4.6.5. Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлнэ.

1.4.7. Ховд хотын инженерийн шугам сүлжээний найдвартай, тасралтгүй байдлыг хангаж, хотын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангана.

1.4.7.1. Хотын усан хангамж, ариутгах татуурга, дулааны нэгдсэн шугам сүлжээний зураг төсөл, техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ.

1.4.7.2. Дулааны 15 км шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх, шинээр байгуулах ажлыг зохион байгуулна.

1.4.7.3. Цэвэр, бохир усны шугамыг үе шаттайгаар шинэчлэх ажлыг зохион байгуулна.

1.4.7.4. Шинэ суурьшлын бүсэд мэдээлэл холбооны кабелийн сувагчлал байгуулж сүлжээг өргөтгөнө.

1.4.7.5. “Ховд аймгийн дулааны станц, дулааны шугам сүлжээний ашиглалтын өмнөх захиргаа”-г орон нутгийн өмчид шилжүүлж, сэлбэг нөөцийг бүрдүүлэн орчин үеийн өндөр хүчин чадалтай зуухаар шинэчлэл, өргөтгөл хийж, найдвартай ажиллагааг хангаж, дулаан дамжуулах төвүүдийг шинээр барьж байгуулна.

1.4.7.6. Аймгийн цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд орчин үеийн ухаалаг тоолуур суурилуулж цахилгааны төлбөрийг хугацаанд нь барагдуулдаг болно.

1.4.8. Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.4.8.1. Ховд хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хийлгэж, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа орон сууцны барилгуудад дахин төлөвлөлт хийнэ.

1.4.8.2. Гэр хорооллын зарим хэсэгт дахин төлөвлөлт хийж, иргэдийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож, ая тухтай амьдрах орчин бүрдүүлнэ.

1.4.8.3. Наран, Рашаант, Цамбагарав багуудын намагжилт, хөрсний бохирдлыг бууруулна.

1.4.8.4. Их, бага голын завсар “Ховд” цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

1.4.9. Газрын тухай хууль, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагад газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

1.4.9.1. Аймгийн хэмжээнд өмчлүүлэх боломжтой нөөц газруудыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, иргэдэд газар өмчлүүлнэ.

1.4.9.2. Иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад үйлдвэр үйлчилгээний зориулалтаар газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгоно.

1.4.10. Улсын болон орон нутгийн чанартай баталгаажсан зам, орон нутгийн зам, гудамж, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулна.

1.4.10.1. Улсын болон орон нутгийн чанартай баталгаажсан зам, орон нутгийн замын дагуу тэмдэг, тэмдэглэгээг байршуулна.

1.4.10.2. Ховд хотын гудамж, талбай, үл хөдлөх хөрөнгийн судалгааг гаргаж, хаягийн зураг хийж, давхардалтыг арилгаж, зураглалын дагуу хаягийн тэмдэг, тэмдэглэгээг байршуулж, нэгдсэн стандартад шилжүүлнэ.

1.4.11. Цахилгаан эрчим хүч, түүний дотор сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, цахилгаан эрчим хүчний хямд, найдвартай эх үүсвэртэй аймаг болно.

1.4.11.1. Эрдэнэбүрэний 64 мВт-ын усан цахилгаан станцыг барина.

1.4.11.2. Алтай, Үенч, Булган сумдыг бие даасан сэргээгдэх цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болгоно.

1.4.11.3. Мянгад суманд нарны эрчим хүчний 10 мВт цахилгаан станц байгуулна.

1.5. Уул уурхайн чиглэлээр:

Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана.

1.5.1. Хөшөөтийн нүүрсний уурхайн үйл ажиллагааг тогтмолжуулж, орон нутгийн хөгжлийг бодит үр дүнд хүргэнэ.

1.5.1.1. “Хөшөөт хөгжлийн гарц” төсөл хэрэгжүүлж, харилцан ашигтай байдлаар хамтран ажиллана.

1.5.1.2. Хөшөөтийн нүүрсний уурхай болон туслах үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг ажиллуулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.5.2. Газрын тосны эрэл, хайгуулыг эрчимжүүлнэ.

2. НИЙГМИЙН БОДЛОГО:

Эрүүл, боловсролтой, ажилтай-орлоготой иргэдтэй, дундаж орлоготой гэр бүл зонхилсон, олон үндэстэн, ястны өв соёл, уламжлалаа дээдэлж, орчин үеийн дэвшилтэт технологийг төлөвшүүлсэн аймаг болно.

2.1. Эрүүл мэндийн чиглэлээр: Хүн амыг аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ.

2.1.1. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж, эрсдэлт хүчин зүйл, өвчлөл эндэгдлийг тууштай бууруулан, хүн амын цэвэр өсөлтийг хангаж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

2.1.1.1. Төрөлтийг дэмжиж, нас баралтыг бууруулах замаар эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт болох хүн амын дундаж наслалтыг 73,5-д хүргэнэ.

2.1.1.2. Халдварт бус өвчний эрт илрүүлэлтийг 50-иас дээш хувьд хүргэж, хавдрын тусламж үйлчилгээний өрөө тасалгаа, хүн хүчний нөөцийг нэмэгдүүлэн, хөнгөвчлөх эмчилгээг өргөжүүлнэ.

2.1.1.3. Осол гэмтэл, амны хөндий, эмийн хэрэглээ, хавдар зэрэг иргэдийн эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгааны ажлыг хийж, орон нутгийн эрэлтэд суурилсан “Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.1.4. Амны хөндийн өвчлөлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, Булган суманд шүдний эмчилгээний кабинет байгуулан ажиллуулна.

2.1.1.5. Халдварт өвчний тархвар зүй, тандалт судалгааны ажлыг эрчимжүүлэн, шаардлагатай оношлуур, вакцин урвалж бодисоор хангах боломжийг судлан шийдвэрлэж, вирусын гаралтай халдварт өвчнийг орон нутагтаа оношилно.

2.1.1.6. Хүний дархлал хомсдлын вирус, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, элэгний В,С вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эмчлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.1.7. Амьсгалын замаар дамжих халдварт өвчин, ялангуяа улаан бурхан, улаанууд зэрэг өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулна.

2.1.1.8. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, устгалын журмыг хэрэгжүүлж, хог хаягдлын байгууламжийг шинээр байгуулж ашиглана.

2.1.1.9. Эрүүл мэндийн салбарт хэрэгжих гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулан үр дүнг дээшлүүлнэ.

2.1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээг улсын болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлж, үйлчлүүлэгчдийн ая тухтай, ээлтэй орчин бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.2.1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг орчин үеийн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжид суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх төв болгон өргөжүүлнэ.

2.1.2.2. Олон улсын жишигт ойртуулсан “Оношилгооны төв”-ийн барилгыг шинээр барьж, нотолгоонд тулгуурласан оношилгоог өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нягтралыг сааруулах арга хэмжээг авна.

2.1.2.3. Жаргалант суманд эмнэлэг (Хүүхдийн эмнэлэг) байгуулж, Булган сумын нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулж, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.2.4. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Халдвартын барилгын засварыг дуусгаж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлнэ.

2.1.2.5. Рашаант, Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг барьж, Бугат өрхийн эмнэлгийн барилгыг багийн төвийн хамт цогцоор нь шийдвэрлэнэ.

2.1.2.6. Зооноз өвчин судлалын төвийн барилгыг барьж, хээрийн судалгаа шинжилгээний авто машинтай болгоно.

2.1.2.7. БОЭТ, сумдын эмнэлгүүдийн яаралтай тусламжийн машин, багийн эмч нарын унааг дэс дараатайгаар шинэчилнэ.

2.1.2.8. Цэцэг, Алтай сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг өргөтгөж, Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад, Дөргөн, Дарви, Чандмань, Мөнххайрхан сумдын эрүүл мэндийн төвийн барилгыг засварлана.

2.1.2.9. Эрүүл мэндийн газрын барилга, БОЭТ-ийн туслах барилгуудын засварыг хийнэ.

2.1.2.10. “Мянган угалзат” Орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын барилгын өмчлөл, засвар, урсгал зардлыг шийдвэрлүүлж, БОЭТ-ийн амбулатори, уламжлалт эмчилгээний төв болгон өргөжүүлж, эмнэлгийн ачааллыг бууруулах арга хэмжээг авна.

2.1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай байдлыг эрхэмлэн, тусламж үйлчилгээнээс “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг нэвтрүүлнэ.

2.1.3.1. Жил бүр иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд явуулын хэлбэрээр хамруулж, өвчлөлийг эрт илрүүлж, эмчлэх арга хэмжээг авна.

2.1.3.2. Салбарын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, байгууллага, иргэний итгэлцлийг сайжруулж, зарим шаардлагатай байгууллага, тасаг нэгжүүдэд “Шилэн эмнэлэг” үйл ажиллагааг нэвтрүүлнэ.

2.1.3.3. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, иргэдийг орон нутагтаа оношилгоо, эмчилгээ авах боломжийг бүрдүүлж, өдрийн болон эмийн бус эмчилгээг гүйцэтгүүлэн зардлыг даатгалаас санхүүжүүлнэ.

2.1.3.4. Эх, хүүхдийн тусламжийн чанарыг сайжруулах “Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ”-г нэвтрүүлж, 5 хүртэлх насны хүүхдэд амбулаториор олгох эмийг үнэгүй олгож, эх хүүхдийн эндэгдлийг бууруулна.

2.1.3.5. Эрүүл мэндийн газрын “Өсвөр үе ирээдүйн босго төв”-ийг “Залуусын эрүүл мэндийн боловсрол” олгох төв болгон өргөжүүлж, нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө, тусламжийг тасралтгүй үзүүлэх боломжоор хангана.

2.1.3.6. Эрүүл мэндийн байгууллагуудын эрэлт хэрэгцээнд үндэслэн эмнэлгүүдийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, хатуу, зөөлөн эдлэлийг шинэчлэх “Үйлчлүүлэгчийн ээлтэй орчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.3.7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг өргөжүүлж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, сувилал байгуулах үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, тусламж, үйлчилгээний чанарт тавих хяналтын тогтолцоог сайжруулна.

2.1.3.8. Эрүүл мэндийн салбарын цахим мэдээллийн тогтолцоог өргөжүүлэн, цахим үйлчилгээг өргөжүүлж, шаардлагатай тасгууд болон алслагдсан зарим сумдыг үндэсний лавлагаа төвүүдтэй зайн оношилгоонд холбож, нотолгоонд тулгуурласан оношилгоо, эмчилгээний шуурхай байдлыг дээшлүүлнэ.

2.1.3.9. Эмийн чанар, зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг эрхэмлэн, өндөр идэвхтэй баталгаатай, чанартай эмээр ард иргэдийг ханган, шинээр эмийн сан байгуулахыг дэмжинэ.

2.1.4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, шаардлагатай эмч, мэргэжилтнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.4.1. Орон нутагт нэн шаардлагатай (тархины мэс засал, охид, эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, хүүхдийн эрчимт эмчилгээ, ургийн гажиг

оношилгоо, халдвартын эмч, халдвар судлаач г.м) эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.

2.1.4.2. Эрүүл мэндийн салбарын гадаад харилцааг өргөжүүлэн эмч, сувилагч, мэргэжилтнийг өндөр хөгжилтэй улс оронд сурган, дадлагажуулахын зэрэгцээ гадаад, дотоодын ур чадвартай эмч, мэргэжилтний багийг орон нутагт ажиллуулж, харилцан туршлага судлуулах “Эмч-солилцоо” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.4.3. Сум, өрхүүдийн эмнэлгийг стандартын дагуу эмч, мэргэжилтнээр хангаж, хүүхэд, эх барих, уламжлалт эмчилгээ, өрхийн эмчийг мэргэшүүлэн сургаж, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг сумын удирдлагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.2. Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:

Бүх шатны боловсролын үйлчилгээнд стандартад суурилсан тогтолцоог бүрдүүлж, сургуулийг хөгжлийн төв болгон хөгжүүлнэ.

2.2.1. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших боломжийг бүрдүүлж, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

2.2.1.1. Сургуулийн бүтэц хэв шинж хамран сургах тойргийг шинэчлэн мөрдүүлнэ.

2.2.1.2. Сургуулийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

2.2.1.3. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.1.4. Төрийн болон хувийн цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулж, цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

2.2.1.5. Насан туршийн боловсролын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, дүйцсэн хөтөлбөрийн суралцагчдыг “Үдийн цай хөтөлбөрт” хамруулна.

2.2.1.6. Дотуур байрны эрүүл аюулгүй орчны стандартыг боловсруулан мөрдүүлж, 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа халамж хөгжлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

2.2.2. Багш нарын хөгжлийг дэмжинэ.

2.2.2.1. Сургуулиудын цахим сургалтын орчныг сайжруулж, цахим хичээлийн сан бүрдүүлж, түгээнэ.

2.2.2.2. Боловсрол, соёл, урлаг, спортын салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулж, сургалт арга зүйн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлнэ.

2.2.2.3. Сургууль, багш нарын тэргүүний арга технологийг судлан түгээн дэлгэрүүлнэ.

2.2.2.4. Лаборатори сургуульд орон нутгийн иргэдийн онцлогт нийцсэн сургалтын хөтөлбөрийг туршиж хэрэгжүүлнэ.

2.2.3. Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлэн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлнэ.

2.2.3.1. Иргэд, сургуулийн хамтын оролцоог сайжруулахад чиглэсэн “Сургууль-хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2.3.2. Боловсролын үйл ажиллагаанд нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлж, олон нийтийн оролцоотой сургуулийг хөгжүүлнэ.

2.2.3.3. Орон нутгийн онцлогтой уялдуулан “Номын гэгээ” дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.2.3.4. Гүнзгийрүүлсэн, төрөлжсөн сургалтыг өргөжүүлнэ.

2.2.3.5. АНУ-ын Элчин сайдын яамнаас хэрэгжүүлж байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх “Ментор”, “Аксес” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.2.3.6. Гадаадын их дээд сургуульд суралцагсдыг бэлтгэдэг туршлагатай багш нарыг түшиглэн орон нутгийн багш, сурагчдыг чадваржуулах арга хэмжээг авна.

2.2.3.7. Ахлах ангийн сурагчдын сонгон суралцагчдын хөтөлбөр арга зүйг боловсруулан хэрэгжүүлж, элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээг ахиулж 515-д хүргэнэ.

2.2.3.8. Орон нутгийн онцлогтой уялдуулан “Чадварлаг Ховдчууд” дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.2.4. Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчинг сайжруулна.

2.2.4.1. Сургууль, цэцэрлэг, сургалтын байгууллагуудыг өндөр хурдны интернетэд холбож, мэдээлэл харилцаа, технологийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ.

2.2.4.2. Багшийг хөгжүүлж чадавхжуулах, ажиллах орчин нөхцлийг сайжруулах “Багшийн хөгжлийн ордон”-г байгуулна.

2.2.4.3. Жаргалант суманд дотуур байр бүхий сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулж, Тахилт, Цамбагарав, Наран, Бугат багуудад хүүхдийн цэцэрлэг байгуулж, 7, 9, 10 дугаар цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, 2, 6, 11 дүгээр цэцэрлэг, III, VI сургуулийн барилгыг засварлана.

2.2.4.4. Ховд сумын 2 дугаар, Мянгад сумын цэцэрлэгийн барилгыг шинээр барьж, Алтай, Манхан сумын цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, Цэцэг, Ховд, Булган, Эрдэнэбүрэн, Мөнххайрхан сумдын цэцэрлэгийн барилгыг засварлана.

2.2.4.5. Булган сумын 1 дүгээр сургуулийн спорт заалны барилгыг шинээр барьж, Буянт, Дарви, Цэцэг, Ховд, Мөнххайрхан, Дуут сум, Булган сумын I, II сургуулийн хичээлийн байр, II сургуулийн дотуур байр, Чандмань сумын сургуулийн спорт заал, Буянт сумын сургуулийн хуучин дотуур байрны барилгыг засварлана.

2.2.4.6. Аймгийн төвийн цэцэрлэгүүдийг камержуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.2.4.7. Ховд Их сургуульд баруун бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан хэрэглээний шинжлэх ухаан, инженер технологийн мэргэжлийн ангиудыг нээхийг бодлогоор дэмжинэ.

2.2.4.8. Ховд Их сургуулийн харьяа математик, байгалийн ухаан, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Лицей сургуулийн барилгын засварыг хийнэ.

2.3. Соёл урлагийн чиглэлээр:

2.3.1. Соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлнэ.

2.3.1.1. Музейн хадгалалт, хамгаалалтыг олон улсын стандартад ойртуулж, үзмэр худалдан авалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.

2.3.1.2. Соёлын биет болон биет бус өвийн нэгдсэн цахим сантай болж, соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн хөгжүүлнэ.

2.3.1.3. Соёлын биет, биет бус өв, түүх соёлын дурсгалыг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан иргэд, өвлөн уламжлагчдыг урамшуулах журам боловсруулан хэрэгжүүлнэ.

2.3.1.4. Сумдын орон нутаг судлах кабинетүүдийн үзмэр худалдан авалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан, нутгийн иргэдэд хадгалагдаж байгаа түүхийн болон эд өлгийн үнэт зүйлсийг орон нутгийн хамгаалалтанд авна.

2.3.2. Олон үндэстэн, ястнуудын язгуур урлагийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж, өвлүүлэн хөгжүүлнэ.

2.3.2.1. Орон нутгийн дэмжлэгтэйгээр “Олон үндэстэн, ястны өв соёл” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.3.2.2. Сумдад ардын язгуур урлагийн төвүүдийг байгуулж, олон угсаатны бүлгүүдийн ардын язгуур урлагийг өвлүүлэн хөгжүүлж, дэлхий нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулна.

2.3.2.3. Монгол хөөмий, тууль, цуур, бие биелгээ, айтыс наадам зохион байгуулна.

2.3.2.4. Олон үндэстэн, ястны олон улсын фестиваль наадам, цас мөсний баярыг 2 жилд нэг удаа зохион байгуулна.

2.3.3. Соёл урлагийн салбарыг орон нутгийн онцлогтой уялдуулан хөгжүүлж, мэргэжилтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлнэ.

2.3.3.1. Соёл урлагийн чиглэлээр хөрш зэргэлдээ орнуудын мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, олон улс болон улс, бүсийн уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.3.3.2. Соёл, урлагийн салбарын уран бүтээлч, ажилчдын ур чадварыг дээшлүүлж мэргэшүүлэх, нарийн мэргэжлийн уран бүтээлчдийг бэлтгэх, онцгой авьяастай хүмүүсийг гадаад дотоодын их, дээд сургуульд тэтгэлгээр сургах нөхцлийг бүрдүүлж, мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг 80-аас дээш хувьд хүргэнэ.

2.3.3.3. Соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

2.3.3.4. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран “Кино театр”-ын үйл ажиллагааг өргөжүүлэн, орон нутгийн иргэдэд кино урлагаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.3.3.5. “Оюун түлхүүр” хөтөлбөр хэрэгжүүлж, нийтийн номын сан болон сумдын номын сангийн ном худалдан авах зардлыг жил бүр олгож, фонд баяжилтыг нэмэгдүүлнэ.

2.3.3.6. “Цахим номын сан” хөтөлбөр хэрэгжүүлж, сумдын номын сангийн үйл ажиллагааг цахимжуулж, иргэдэд цахимаар үйлчлэх боломж бүрдүүлнэ.

2.3.3.7. Америкийн элчин сайдын яамны олон нийттэй харилцах албатай хамтран “Америкийн мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

2.3.4. Соёл урлагийн салбарын материаллаг орчин нөхцлийг сайжруулна.

2.3.4.1. Аймгийн Музейн барилгыг шинээр барьж, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлнэ.

2.3.4.2. Өв соёлын хүрээлэнг олон үндэстэн, ястны “Маануус” цэнгэлдэх хүрээлэн болгон өргөжүүлж, баруун Монголын түүх, өв соёлыг сурталчлан, түгээн дэлгэрүүлнэ.

2.3.4.3. Жаргалант суманд ардын соёл урлагийн “Икэл” цогцолборыг барьж, олон үндэстэн, ястны ардын урлагийг хөгжүүлнэ.

2.3.4.4. Дөргөн, Цэцэг, Буянт сумдын соёлын, Дуут, Мөнххайрхан сумдын соёл, спортын төвийг шинээр барьж, Дарви, Ховд, Алтай сумдын соёлын төвийн барилгыг засварлана.

2.3.4.5. Булган сумын Соёлын ордны засварыг хийж, орон тоог нэмэгдүүлнэ.

2.3.4.6. Аймгийн Хөгжимт драмын театрын барилгын их засвар хийж, “Олон үндэстэн, ястны эрдмийн театр” болгон өргөжүүлнэ.

2.3.4.7. Хөдөө орон нутгийн иргэдэд соёл урлагаар үйлчлэх боломжийг бүрдүүлэн Хөгжимт драмын театрыг үйлчилгээний автобустай болгоно.

2.3.4.8. Нийтийн номын сангийн өргөтгөлийн барилгыг барьж, хүүхдийн номын өргөөг засварлаж, сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд зориулсан тоглоомын өрөө, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэнхимийг нээнэ.

2.3.4.9. Соёл урлагийн байгууллагуудын техник, тоног төхөөрөмж, эд хогшлыг үе шаттайгаар шинэчилнэ.

2.4. Биеийн тамир, спортын чиглэлээр:

2.4.1. Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.1.1. Орон нутгийн дэмжлэгтэйгээр “Спортын аварга” хөтөлбөр, тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.4.1.2. Олон улсын болон улсын аврага шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, тамирчид, дасгалжуулагчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, олон улс, улс, бүсийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

2.4.1.3. Усан спортын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан, орон нутгийн иргэдийг усан спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлнэ.

2.4.2. Иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаална.

2.4.2.1. Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулан, олон нийтийг хамарсан арга хэмжээ, аянуудыг өрнүүлнэ.

2.4.2.2. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, гүйлт, иог, фитнесээр хичээллүүлж, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын оролцоог дээшлүүлнэ.

2.4.2.3. Өвлийн спортыг хөгжүүлж, олон улсын чанартай спортын арга хэмжээг зохион байгуулна.

2.4.2.4. Бүсийн бага олимпийг зохион байгуулна.

2.4.3. Биеийн тамир, спортын материаллаг орчин нөхцлийг сайжруулна.

2.4.3.1. Булган суманд спортын ордон барьж, ашиглалтанд оруулна.

2.4.3.2. Аймгийн төвд хүүхэд, залуучуудын хөл бөмбөгийн “Титэм” стадионыг барина.

2.4.3.3. Аймгийн Биеийн тамир, спортын газарт спортын төрлүүдээр бэлтгэлийн дэвжээ, заалуудыг байгуулан тохижуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх боломжийг бүрдүүлнэ.

2.4.3.4. Усан бассейн, спортын ордны бага заалыг засварлаж, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.3.5. Биеийн тамир, спортын салбарын дасгалжуулагч, тамирчдыг уралдаан тэмцээнд оролцуулах боломжийг бүрдүүлэн автобус олгож, техник тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

2.5. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

2.5.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажилтны тоог нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулж, “Зохистой ажлын байр”-ыг дээдэлсэн аймаг болно.

2.5.1.1. Аймгийн хэмжээний хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийнэ.

2.5.1.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар шинэ байнгын болон улирлын ажлын байрыг жил бүр 500-аар нэмэгдүүлнэ.

2.5.1.3. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгох, Улаанбаатар хот, хөрш зэргэлдээ улсуудад нэрийн барааны борлуулалтын цэг, үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.

2.5.1.4. “Өрх толгойлсон эх/ эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.5.1.5. “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан” байгуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.

2.5.1.6. “Хөгжил” политехник коллежийн хичээлийн байрны өргөтгөлийг барьж, сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн шинэчилж, түншлэлийг өргөжүүлнэ.

2.5.1.7. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.5.2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, зорилтот бүлгийн нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулна.

2.5.2.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.5.2.2. "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай" хуулинд хамрагдаж, шимтгэлээ төлж чадаагүй эмзэг бүлгийн иргэдийн асуудлыг шийдвэрлэнэ.

2.5.2.3. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлын ажиллах нөхцөл, иргэдэд үйлчлэх эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг сайжруулна.

2.5.2.4. Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулна.

2.5.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, стандартыг мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.5.2.6. "Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

2.5.2.7. Нэвтийн амралтыг ахмадын рашаан сувилал болгон өргөжүүлж, иргэдэд хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчлэх боломжийг бүрдүүлж, хүүхдийн "Баянбулаг" зуслангийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.

2.5.2.8. Хүүхэд залууст ажлын дадлага туршлага, мэргэжлийн ур чадварыг өвлүүлэн сургах зорилго бүхий "Ахмадын зөвлөх үйлчилгээ" арга хэмжээг зохион байгуулна.

2.5.2.9. Ахмадын ордны үйл ажиллагааг өргөжүүлж, ахмадын чөлөөт цагийг өнгөрүүлэх "Хөгжлийн төв"-тэй болгоно.

2.5.2.10. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр зорчих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.

2.5.2.11. "Ахмадаа ачлая" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ

2.5.3. Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, оролцоог бүх талаар дэмжиж, орчин нөхцлийг сайжруулна.

2.5.3.1. "Гэр бүлийг дэмжих" дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.5.3.2. "Зөв хөдөлмөрч залуу" залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.5.3.3. "Жендэрийн тэгш байдлыг хангах" аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.5.3.4. Хүүхдийн ордны Хүүхэд хөгжүүлэх дугуйлангийн үйл ажиллагааг тогтмолжуулж, аймгийн Засаг даргын дэргэдэх "Хүүхдийн дуу бүжгийн чуулга" байгуулна.

2.5.3.5. Хүүхдийн ордны барилгыг засварлаж, хэвийн үйл ажиллагааг хангана.

2.5.3.6. "Баруун Монголын хүүхдүүд" баруун 5 аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган, язгуур урлагийн наадмыг аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулна.

2.5.3.7. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын унааны асуудлыг шийдвэрлэнэ.

2.5.3.8. Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмадууд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын бүлгийг хамарсан чуулганыг зохион байгуулж, шийдвэр гаргах түвшинд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.5.4. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүл, хүүхэд, залуучуудын хамгааллыг сайжруулна.

2.5.4.1. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүд, гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах “Хамгаалах төв”-ийг стандартын дагуу байгуулна.

2.5.4.2. “Гэр бүлд зөвлөгөө өгөх” төвийг стандартын дагуу тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.5.4.3. ”Гэрэлт ирээдүй-Хадгаламж”бүтэн өнчин хүүхдүүдэд олгох тэтгэлгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.5.4.4. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Хүүхдийн төлөө сан” байгуулж хүнд нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмыг боловсруулан мөрдүүлж, хүүхдийн сайн сайхны төлөө зарцуулна.

3. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО:

Байгаль хамгаалах уламжлалт арга, зан үйлийг дээдэлсэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалсан, эдийн засаг, нийгмийн хөгжил нь ногоон хөгжлийн бодлогод бүрэн нийцсэн загвар аймаг болно.

3.1. Байгаль орчноо хамгаалах, түүний нөөц баялгийг арвилан хэмнэх, зохистой хэрэглэх чиг хандлага, сэтгэлгээ, зан үйлийг бүх шатны албан болон албан бус боловсролын системээр дамжуулан төлөвшүүлнэ.

3.1.1. Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санааг бүх шатны сургалтын хөтөлбөрөөр дамжуулан байгаль хамгаалах уламжлалт ёс заншлаа өвлүүлэх, арвилан хэмнэх чиг хандлага, сэтгэлгээг бий болгоно.

3.2.Биологийн олон янз байдлын суурь судалгааг хийж, тэдгээрийг хамгаалах, үржүүлэх, зохистой ашиглах бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

3.2.1. Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нутаг, усны эх, байгалийн үзэсгэлэнт өвөрмөц тогтоцтой, түүхийн дурсгалт газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд нийт газар нутгийн 45 хувийг хамруулна.

3.2.2. Тахь, Хар сүүлтий, Бөхөн, Хулан зэрэг амьтдын судлагдсан байдал, хамгаалалтын талаар хийгдсэн ажлыг нэгтгэж мэдээллийн сан бүрдүүлнэ.

3.2.3. Аймгийн нутаг дэвсгэрт агнуур зохион байгуулалтын судалгааг хийлгэж, ан амьтдын байршил, нөөцийг тогтоосны үндсэн дээр зохистой ашиглалтыг бий болгоно.

3.2.4. Хөрсний үржил шим, ургамлын доройтол, цөлжилтийг сааруулах зорилгоор жилд 30 га-аас доошгүй талбайд мод тарьж, ойн санг нэмэгдүүлнэ.

3.2.5. Хот суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, бичил цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулна.

3.2.6. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж, чадавхжуулна.

3.3. Орчны бохирдлыг бууруулах замаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

3.3.1. Хог хаягдлыг бууруулах ангилан ялгах талаар иргэдийн мэдлэг, ухамсарыг дээшлүүлэх, дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.

3.3.2. Ландфиллийн аргаар сумдын хур хог хаягдлыг устгах, хог хаягдал зайлуулах техник хэрэгсэлтэй болгож, хог хаягдлыг боловсруулах жижиг үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэмжинэ.

3.3.3. Ховд хотын агаарын бохирдлыг бууруулах, бүрэн шаталттай ахуйн хэрэгцээний стандартын зуухыг орон нутагт нийлүүлэх, зарим барилга, байгууламжийг байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашиглан халаах замаар нүүрсний хэрэглээг бууруулна.

3.3.4. Аймгийн агаарын бохирдлыг бууруулах талаар эрх зүйн баримт бичгийг гаргаж мөрдөн ажиллана.

3.4. Газар, газрын хэвлийн доройтлыг бууруулах, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлж, дүйцүүлэн хамгаалах замаар хуримтлагдах нөлөөллийг бууруулна.

3.4.1. Хууль бус аргаар ашигт малтмал олборлохны нөлөөгөөр эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газруудад нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.

3.4.2. Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийг албажуулах, зохион байгуулалтад оруулах замаар байгаль орчныг хамгаалах хариуцлагыг нэмэгдүүлнэ.

3.4.3. Хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлж, нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалтыг сайжруулан хуримтлагдах нөлөөллийг бууруулна.

3.5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хуульд заасан тодорхой хувь хэмжээгээр байгалийн нөөцийг хамгаалах, орчны доройтлыг бууруулахад зарцуулна.

3.6. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах хүрээнд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.6.1. Үүлэнд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар гаралтын тоог нэмэгдүүлж ажиллана.

3.6.2. Өндөр уулын бүсийн сумуудад газрын генератор суурилуулах ажлыг шат дараатайгаар авч хэрэгжүүлнэ.

3.7. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, ус хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулах замаар гүний усны хэрэглээг бууруулна.

3.7.1. Гадаргын болон гүний усны тооллого явуулна.

3.7.2. Айл өрх, аж ахуйн нэгжүүдийг зардал хуваах зарчмаар тоолууржуулснаар усны зохистой хэрэглээг бий болгож хэвшүүлнэ.

3.7.3. Булаг шандны эхийг хамгаалж, хөв, цөөрөм байгуулах замаар гүний усны хэрэглээг бууруулна.

3.8. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.8.1. Гурван сэнхэр төвтэй “5 од” хөтөлбөр хэрэгжүүлж, олон үндэстэн, ястны ахуйн соёл, зан заншил, уламжлал, түүх, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар гадаад, дотоодын аялагчдын тоог нэмэгдүүлнэ.

3.8.2. Аялал жуулчлалын мэдээллийн сан бий болгох, цахим бүртгэл хийх ажлыг тогтмолжуулах, мэдээллийн төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна.

3.8.3. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу нийтийн ариун цэврийн газар, иж бүрэн үйлчилгээ бүхий түр буудаллах цэг байгуулж, тэмдэгжүүлэлт хийнэ.

4. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын удирдлага, албан хаагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангасан, ил тод, нээлттэй, хүртээмжтэй үйлчилгээг дээдэлсэн мэргэшсэн төрийн албыг бэхжүүлнэ.

4.1.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын чадавхийг дээшлүүлэх:

Оновчтой бүтэц, хариуцлагатай албан хаагч, иргэн төвтэй, шударга, хяналттай, төр, захиргааны байгууллагыг бэхжүүлнэ.

4.1.1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой болгож, чиг үүргийн давхардлыг арилган, ажлын уялдааг сайжруулж, цомхон чадварлаг, мэргэшсэн болгоно.

4.1.1.1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт “Угтах үйлчилгээ”-г нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх боломж бүрдүүлнэ.

4.1.1.2. Иргэдэд үйлчлэх “Нэг цонхны үйлчилгээний төв”-ийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг дээшлүүлнэ.

4.1.1.3. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад ISO-9001 стандартыг нэвтрүүлнэ.

4.1.2. Бүх шатны ИТХ-ын үйл ажиллагааг дэмжиж, нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо, хяналтыг тогтмолжуулна.

4.1.2.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас гарах шийдвэрт иргэд хөдөлмөрчдийн санал бодлыг тусгуулж, хэрэгжилтийг нь тайлагнадаг, иргэдийн оролцоотой нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг дэмжиж ажиллана.

4.1.2.2. Багуудын Иргэдийн нийтийн хурлыг хууль эрх зүйн хүрээнд ажиллуулж, багаас иргэдтэй ажиллах ажлыг шинэ шатанд гаргана.

4.1.3. Төрийн албан хаагчдыг чадавхжуулж, үүрэг хариуцлагыг дээшлүүлнэ.

4.1.3.1. Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт, удирдлага, мэдээллийн цахим тогтолцоо нэвтрүүлнэ.

4.1.3.2. Төрийн албан хаагчдыг үе шаттайгаар сургалтанд хамруулж, ур чадварыг нь дээшлүүлнэ.

4.1.3.3. Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд үе, залуучуудын төлөөллийн уулзалтыг 2 жилд 1 удаа зохион байгуулж, гарсан санал зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

4.1.3.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр дүнг бодлого, төлөвлөлтөнд тусгах, үр дүнтэй ашиглах чадавхийг бүх шатанд бий болгоно.

4.1.3.5. Төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээг судалгааны байгууллагаар гүйцэтгүүлнэ.

4.1.4. Бүх шатны төрийн албан хаагчиддаа үнэнч шударга, ёс зүйтэй, тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлнэ.

4.1.4.1. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах болон орон сууцны нөхцлийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд албан байгууллагуудад дэмжлэг үзүүлнэ.

4.1.4.2. Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх саналыг төр, засгийн бодлогод тусгуулан хэрэгжүүлнэ.

4.1.5. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, авлигаас ангид төрийн албыг бэхжүүлнэ.

4.1.5.1. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж, “Иргэдийн хяналтын зөвлөл” байгуулж хамтран ажиллана.

4.1.5.2. Төрийн албаны ёс зүйг баримтлах зарчмыг мөрдүүлэх, авлигын эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

4.1.5.3. Авлигагүй, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд төр, захиргааны байгууллагуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлнэ.

4.1.6. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын орчин нөхцлийг дээшлүүлнэ.

4.1.6.1. Эрдэнэбүрэн, Ховд, Чандмань сумдад “Нутгийн удирдлагын ордон” шинээр барих ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

4.1.6.2. Сумдын Засаг даргын Тамгын газрын үйлчилгээний авто машиныг эдэлгээ норм, хэрэгцээ шаардлагыг харгалзан системтэй шинэчилнэ.

4.1.6.3. Багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлж, хамтын оролцоотой унаажуулна.

4.1.7. Төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, цахим засаглалыг хэрэгжүүлнэ.

4.1.7.1. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх замаар үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэнэ.

4.1.7.2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг дэмжиж чадавхжуулах хөтөлбөрт хамруулах, төрөөс хамтарч ажиллахдаа тэгш зарчим баримтлах зэргээр тухайн салбарын санал санаачилгыг хуулийн хүрээнд дэмжин ажиллаж төрийн үйлчилгээг олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдүүлнэ.

4.1.7.3. Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай баримтыг тоон хэлбэрт шилжүүлж, салбар бүрийн цахим мэдээллийн нэгдсэн сан /цахим архив/ бүрдүүлнэ.

4.1.8. Төр, иргэн, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргаж, ажлын уялдаа холбоог сайжруулна.

4.1.8.1. Шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн саналыг авч, нийгмийн бүлгүүдийн оролцоонд тулгуурлаж, олонхийн эрх ашгийг дээдэлсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.1.8.2. Төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, орон нутгийн хөгжилд оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.1.8.3. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлнэ.

4.1.9. Засаг захиргааны анхан шатны нэгж багийн үйл ажиллагааг дэмжинэ.

4.1.9.1. Багуудыг шинэ төвтэй болгох, багийн төвийг тохижуулах, засварлах, алслагдсан, нутаг бэлчээр том, хүн ам олонтой багуудыг хөдөлгөөнт төвтэй болгох асуудлыг хэрэгцээ шаардлага, судалгаанд тулгуурлан иргэд, орон нутгийн оролцоотой шийдвэрлэнэ.

4.1.9.2. Судалгаа, хэрэгцээ шаардлаганд үндэслэн зарим багийн төвийг цахилгаан эрчим хүчний найдвартэй эх үүсвэрт холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.10. Аймгийн хэмжээнд тохиох тэгш ойн арга хэмжээнүүдийг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилтай хослуулан ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлнэ.

4.1.10.1. Төрийн тахилгат Алтан Хөхий хайрханы тэнгэрийг тайх арга хэмжээг ёслол төгөлдөр зохион байгуулна.

4.1.10.2. Ойрадын их соён гэгээрүүлэгч Заяа бандит Намхайжамцын мэлмий гийсний 420 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлнэ.

4.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлнэ. Гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалж, бүс нутгийн хамтын ажиллагаанд оновчтой оролцож, худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

4.2.1. ОХУ-ын стратегийн түншлэл, БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд хил залгаа, хөрш зэргэлдээ бүс нутагтай худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

4.2.1.1. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагааны механизмын хүрээнд Бүс нутгийн хамтын ажиллагааны төлөвлөлтийн төв байгуулна.

4.2.1.2. “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хүрээнд дэд бүтцийн чиглэлээр урьдчилан тохиролцсон төслүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.1.3. “Монгол экспорт” хөтөлбөрийн хүрээнд “Ховд-Экспо” үзэсгэлэн яармаг, арга хэмжээг хил залгаа бүс нутгийн хэмжээнд зохион байгуулна.

4.2.1.4. Сум, албан байгууллагуудыг хөрш зэргэлдээ муж, хот, байгууллагуудтай харилцан туршлага солилцох, эдийн засаг, бизнесийн салбарт хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжинэ.

4.2.2. Гуравдагч хөрш болон бусад улс оронтой уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

4.2.2.1. “Алтай бидний нийтийн гэр” олон улсын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд оновчтой оролцож, гадаадад аймаг орноо сурталчлан таниулах, аялал жуулчлал, хамтын ажиллагааг хөгжлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.2.2.2. АНУ, Герман, Солонгос, Япон зэрэг гуравдагч орнуудын муж, хотуудтай харилцан ажиллах харилцааг нэмэгдүүлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ.

4.2.3. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын төсөл хөтөлбөр, бүс нутгийн бусад байгууллагуудын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.

4.2.3.1. НҮБ, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулж, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр, өгөөжийг дээшлүүлнэ.

4.2.3.2. Олон улсын байгууллагуудтай харилцах харилцааг бүх талаар дэмжиж, орон нутагт төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг татна.

4.3. Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр:

4.3.1. “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-т нийцүүлэн, батлан хамгаалах тогтолцооны хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, батлан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.1.1. “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийг орон нутагт сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

4.3.1.2. Цэрэг татлага, цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг чанартай явуулж, цэргийн дайчилгааны бэлтгэл үүрэгтний давтан сургалтууд, дайчилгааны сургууль, цугларалтыг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулна.

4.3.1.3. Аймгийн Батлан хамгаалах газрын “Командын байр”, “Цугларах”, “Шилжүүлэх” байруудыг тодотгож, томилгоот бүрэлдэхүүнтэй дадлага хийлгэж хэвшүүлнэ.

4.3.1.4. Дайчилгааны даалгавраар тогтоосон хүнс, шатах тослох материал, эд хөрөнгийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах, нөөцийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.3.1.5. Орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагааг төлөвлөн, зохион байгуулна.

4.3.1.6. Аймаг, сумын удирдлагуудыг Батлан хамгаалах яам, ЗХЖШ-аас явуулах цэрэг, стратегийн сургалтанд хамруулна.

4.3.2. Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлнэ.

4.3.2.1. ЗХ-ний 123 дугаар ангийн сургалтын төвд Батлан хамгаалах Зэвсэгт хүчнийг сурталчлах, сургалт явуулах сургалтын танхим байгуулна.

4.3.2.2. Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын “Дөл” тоглолтыг жил бүр зохион байгуулна.

4.3.3. Орон нутгийн гамшгаас хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, бүх нийтийн оролцоог сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ.

4.3.3.1. Ард иргэдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах аргад сурган дадлагажуулах зорилгоор жил бүр нэг суманд иж бүрэн, 2 суманд удирдах бүрэлдэхүүний гамшгаас хамгаалах дадлага сургууль зохион байгуулна.

4.3.3.2. Гамшгийн аюулын тухай эрт зарлан мэдээллийг бүх нийтэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дохиогоор ажиллах арга ажиллагаанд сургаж дадлагажуулна.

4.3.3.3. Орон нутгийн гамшигтай тэмцэх техникийн чадавхийг сайжруулна.

4.4. Хууль эрх зүйн чиглэлээр:

Бүх шатанд хүний эрхийг дээдэлж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлнэ.

4.4.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах үйл хэрэгт олон нийтийн оролцоог дэмжиж, хууль сахиулах байгууллагуудын чадавхийг бэхжүүлнэ:

4.4.1.1. Хүний эрхийг хөхүүлэн дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.4.1.2. “Олон нийтийн цагдаа”, “Сургуулийн сэргийлэгч”-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж, олон нийтийн байцаагчийн урамшууллыг нэмэгдүүлэх замаар гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл хэрэгт олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.4.1.3. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалахад орчин үеийн тоног төхөөрөмж нэвтрүүлэх /камержуулах/ ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.4.1.4. Хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх талаар хөрш зэргэлдээ аймгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жил бүр “Холболт” арга хэмжээ хэрэгжүүлнэ.

4.4.1.5. Нууц далд аргаар үйлдэгдсэн, зохион байгуулалттай гэмт хэргийн тухай үнэн зөв мэдээллийг худалдан авах журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.4.1.6. Сумдын хэсгийн төлөөлөгч нарыг орчин үеийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр үе шаттайгаар хангаж, ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ.

4.4.1.7. Дарви, Цэцэг, Мөст, Зэрэг сумдыг харьяалан ажиллах цагдаагийн тасгийг Цэцэг суманд байгуулж, гэмт хэргийн гаралтыг бууруулна.

4.4.1.8. Архи, тамхигүй айл өрх, албан газар, сум, баг болох хөдөлгөөн өрнүүлж, “Тайван-Амгалан-Ховдчууд” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.4.1.9. Цагдаагийн байгууллагын албан конторын барилгын өргөтгөлийн асуудлыг судлан шийдвэрлүүлнэ.

4.4.1.10. Төлбөр төлөгчийн оршин суугаа газарт хүрч ажиллах албаны тээврийн хэрэгслээр хангаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлнэ.

4.4.1.11. Нээлттэй, хаалттай хорих ангийн тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан хүмүүжигчийг ажлын байраар хангаж, хөдөлмөрийнхөө хөлсөөр учирсан хохирлыг барагдуулах боломжийг бүрдүүлнэ.

4.4.1.12. Хэрэг учралын газраас эд мөрийн баримт, цогцос зөөвөрлөх зориулалт бүхий тээврийн хэрэгслээр хангаж, Шүүхийн шинжилгээний алба үүргээ шуурхай гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

4.4.1.13. Хүн ам ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн томоохон суманд төрийн үйлчилгээний нэг цэгийн /ТҮЦ/ машин ажиллуулж, улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэнд ойртуулна.

4.4.1.14. Тээврийн хэрэгслийг саатуулах байр, хашааны үйл ажиллагааны төлбөрийн хувь, хэмжээг тогтоолгож, орлогыг нь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх замаар жолоочийн хариуцлагыг дээшлүүлнэ.

4.4.1.15. Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хил хамгаалах үйл хэрэгт орон нутгийн оролцоог хангана.

4.4.1.16. Хилийн заставуудыг сэргээгдэх болон төвийн эрчим хүчээр хангах, гүний худагтай болгох замаар хилчдийн ажиллах нөхцөлийг сайжруулна.

4.4.1.17. Гадаадын иргэн харьяатын газрын Баруун бүс дэх газрын албан конторын байрны асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.4.1.18. Хилийн боомтуудын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын стандартад нийцсэн хяналт, шалгалтын үйл ажиллагааг сайжруулна.

4.4.2. Хууль тогтоомжийг сурталчлах тайлбарлан таниулах, эрх зүйн сургалт сурталчилгаа мэдээллийн ажлыг тогтмол явуулж, иргэдийн нийгмийн амьдралд оролцох эрх, үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.4.2.1. Аймгийн хэмжээнд зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг нэгдсэн хөтөлбөр, удирдамжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

4.4.2.2. “Хууль, журам-миний амьдралд” аяны хүрээнд хууль эрх зүйн мэдээлэл түгээх ажлыг иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлын түвшинг ахиулна.

4.4.2.3. Төлбөрийн чадваргүй, хүчирхийлэлд өртсөн, зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйл ажиллагааг явуулж, тэднийг хууль, хяналтын байгууллагад төлөөлж, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.

4.4.3. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, нийтийн эрх ашигт хамаарах асуудлаар шийдвэр гаргах үйл явцад иргэдийн санал авах, тусгах үндсэн дээр шийдвэрийн бодит хэрэгжилтийг хангана.

4.4.3.1. Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал, агуулга, ач холбогдлыг байгууллага, албан тушаалтанд сурталчлах, тэдэнд мэдлэг олгоход чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.4.3.2. Нийтийн эрх ашигт хамаарах асуудлыг журамласан захиргааны хэм хэмжээний актыг төлөвлөлт, төслийг олон нийтээр заавал хэлэлцүүлж, тэдний оролцоог хангаж, гарсан саналыг нь тусгах замаар шийдвэрийн бодит хэрэгжилтийг хангуулна.

4.4.3.3. Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээг тогтмол хийж, гарсан үр дүнг иргэд, олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

4.4.4. Сум, байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх замаар үйл ажиллагааг нь сайжруулна.

4.4.4.1. Төрийн, төрөлжсөн, байгууллагын архивын аюулгүй байдлыг хангах, хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулна.

4.4.4.2. Төрийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудаас цахимаар нөхөн бүрдүүлэлт хийж, сум, байгууллага төрийн архивын түвшинд цахимаар лавлагаа олгоно.

4.4.5. Бизнес эрхлэгчдэд шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлж, хэрэглэгчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг болно.

4.4.5.1. Хэрэглэгчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийг мэдээ, мэдээллээр хангаж, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх чиг үүрэг бүхий “Хэрэглэгчийн төв”-ийг байгуулж, ажиллах журмыг батлан хэрэгжүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

4.4.5.2. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах Орон тооны бус зөвлөлийг бизнес эрхлэгч, Үйлдвэрчний эвлэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын төлөөлөлтэй байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.

4.4.5.3. Аймгийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах нийтлэг журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

---oOo---